



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/082/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453317, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Намжил

Утас: 70453317, Цахим хаяг: namjilt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,
Утас/факс: 7045-3317,
Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2026.02.02 № УМА-2026/082/МА-СТА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГА Б.ЭНХТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050902

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	326,053,042.80	323,340,050.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА		15,008.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		15,008.00
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	326,053,042.80	323,325,042.80
351	Түүхий эд материал	53,650,000.00	53,650,000.00
3511	Тусгай зориулалттай материал	53,650,000.00	53,650,000.00
354	Хангамжийн материал	272,403,042.80	269,675,042.80
3541	Бичиг хэргийн материал	235,000.00	97,000.00
3542	Аж ахуйн материал	23,667,000.00	9,301,000.00
3547	Бусад хангамжийн материал	248,501,042.80	260,277,042.80
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	273,346,192.44	453,730,369.41
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	273,346,192.44	453,730,369.41
392	Биет хөрөнгө	273,346,192.44	451,527,988.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	148,678,587.00	148,678,587.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-60,996,167.03	-88,907,704.19
39203	Авто-тээврийн хэрэгсэл	122,349,547.78	257,089,255.77
39204	Хуримтлагдсан элэгдэл	-102,577,970.72	-134,304,236.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	273,432,337.59	283,106,600.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-124,296,315.93	-161,248,509.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,148,169.00	41,082,419.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,486,995.25	-26,136,768.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,275,000.00	153,696,956.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,275,000.00	-21,623,611.11
39217	Ном	95,000.00	95,000.00
393	Биет бус хөрөнгө		2,202,381.00
39301	Програм хангамж	495,000.00	2,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-495,000.00	-792,619.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,700,000.00	
39304	Хуримтлагдсан элэгдэл	-2,700,000.00	
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	599,399,235.24	777,070,420.21
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		10,502,980.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		10,502,980.00
413	Өглөг		10,502,980.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		4,350,000.00
4136	Бусад өглөг		6,152,980.00
41361	Байгууллагад төлөх өглөг		4,992,980.00

41362	Хувь хүмүүст төлөх өглөг		1,160,000.00
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	599,399,235.24	766,567,440.21
51	Засгийн газрын хувь оролцоо	599,399,235.24	766,567,440.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,179,073.38	164,179,073.38
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн	164,179,073.38	164,179,073.38
512	Хуримтлагдсан үр дүн	431,072,769.49	598,314,396.61
5121	Өмнөх үеийн үр дүн	431,072,769.49	431,146,191.64
5122	Тайлант үеийн үр дүн		167,168,204.97
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,147,392.37	4,073,970.22
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	599,399,235.24	777,070,420.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,263,257,344.14	2,369,961,499.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	134,641,248.14	276,129,999.36
120	Нийтлэг татварын бус орлого	134,641,248.14	276,129,999.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	350,000.00	550,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,000.00	550,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	88,952,248.14	269,579,999.36
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	45,339,000.00	6,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,128,616,096.00	2,093,831,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	120,058,096.00	12,300,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	115,058,096.00	12,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,008,558,000.00	2,081,531,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,008,558,000.00	2,081,531,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,148,145,711.46	2,185,378,294.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,148,145,711.46	2,185,378,294.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,883,384,425.17	2,127,947,233.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,428,801,303.00	1,651,368,464.82
210101	Үндсэн цалин	1,030,472,613.00	727,181,870.82
210102	Нэмэгдэл	364,933,190.00	839,621,740.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,647,000.00	43,528,864.00
210104	Урамшуулал	9,748,500.00	41,035,990.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	176,711,714.17	205,076,123.38
210201	Тэтгэврийн даатгал	122,370,810.51	142,442,500.83
210202	Тэтгэмжийн даатгал	14,406,509.11	16,611,839.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,170,254.81	8,232,659.83
210204	Ажилгүйдлийн даатгал	6,552,825.71	7,557,825.04
210205	Эрүүл мэндийн даатгал	26,211,314.03	30,231,298.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,267,947.54	50,779,985.81
210301	Гэрэл, цахилгаан	2,914,336.12	4,266,493.21
210302	Түлш, халаалт	30,263,977.92	44,221,337.60
210303	Цэвэр, бохир ус	2,089,633.50	2,292,155.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,683,098.00	63,175,108.00
210401	Бичиг хэрэг	4,839,900.00	3,048,000.00
210402	Тээвэр, шатахуун	25,261,568.00	30,856,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,073,742.00	1,997,138.00
210404	Ном, хэвлэл	348,000.00	16,502,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,692,440.00	10,771,560.00
210408	Бараа материал акталсны зардал	26,467,448.00	
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,494,500.00	17,197,550.00
210604	Урсгал засвар	11,494,500.00	17,197,550.00
2107	Томилолт, зочны зардал	19,879,300.00	12,120,000.00
210702	Дотоод албан томилолт	19,879,300.00	12,120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,704,699.00	11,846,579.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,410,000.00	8,463,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгальн үйлчилгээ	1,190,000.00	1,610,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	317,299.00	242,379.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,278,400.00	1,022,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	142,841,863.46	116,383,422.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,078,096.00	6,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,567,600.00	7,031,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,196,167.46	103,351,922.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	264,761,286.29	57,431,060.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	252,602,752.00	43,938,904.75
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,672,200.00	40,938,904.75
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	196,763,852.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,166,700.00	3,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,158,534.29	13,492,156.24
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,158,534.29	13,492,156.24
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	115,111,632.68	184,583,204.97
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		17,415,000.00

225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		17,415,000.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-17,415,000.00
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	115,111,632.68	167,168,204.90

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,128,966,096.00	2,094,381,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	350,000.00	550,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	350,000.00	550,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	350,000.00	550,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,000.00	550,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,128,616,096.00	2,093,831,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	120,058,096.00	12,300,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	115,058,096.00	12,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		2,081,531,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		2,081,531,500.00
1330	Төсвийн захирагчдаас	2,008,558,000.00	
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,008,558,000.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,128,966,096.00	2,065,310,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,128,966,096.00	2,065,310,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,864,204,809.71	2,007,879,339.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,428,801,303.00	1,651,188,025.82
210101	Үндсэн цалин	688,591,075.00	727,001,431.82
210102	Нэмэгдэл	660,128,628.00	839,621,740.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	63,534,000.00	43,528,864.00
210104	Урамшуулал	16,547,600.00	41,035,990.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	176,711,714.17	205,271,570.38
210201	Тэтгэврийн даатгал	122,370,810.51	142,637,947.83
210202	Тэтгэмжийн даатгал	14,406,509.11	16,611,839.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,170,254.81	8,232,659.83
210204	Ажилгүйдлийн даатгал	6,552,825.71	7,557,825.04
210205	Эрүүл мэндийн даатгал	26,211,314.03	30,231,298.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,227,947.54	46,429,985.81
210301	Гэрэл, цахилгаан	2,914,336.12	4,266,493.21
210302	Түлш, халаалт	32,223,977.92	39,871,337.60
210303	Цэвэр, бохир ус	2,089,633.50	2,292,155.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,771,650.00	42,522,128.00
210401	Бичиг хэрэг	4,849,900.00	2,910,000.00
210402	Тээвэр, шагахуун	25,261,568.00	27,071,030.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,073,742.00	1,803,538.00

210404	Ном, хэвлэл	16,850,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,736,440.00	10,737,560.00
2105	Нормативт зардал		9,720,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		9,720,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,812,500.00	20,409,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,918,000.00	
210602	Тавилга	5,400,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		2,056,000.00
210604	Урсгал засвар	11,494,500.00	18,353,550.00
2107	Томилолт, зочны зардал	19,879,300.00	10,960,000.00
210702	Дотоод албан томилолт	19,879,300.00	10,960,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,704,699.00	14,346,579.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,410,000.00	8,463,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,190,000.00	1,610,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	317,299.00	242,379.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,278,400.00	3,522,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,295,696.00	7,031,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	97,728,096.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,567,600.00	7,031,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	264,761,286.29	57,431,060.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	252,602,752.00	43,938,904.75
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,672,200.00	40,938,904.75
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	196,763,852.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,166,700.00	3,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,158,534.29	13,492,156.24
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,158,534.29	13,492,156.24
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		29,071,100.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		29,071,100.00
	Дотоод эх үүсвэрээр		29,071,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		29,071,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-29,071,100.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	164,179,073.38	4,147,392.37	315,961,136.81	484,287,602.56
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,179,073.38	4,147,392.37	315,961,136.81	484,287,602.56
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			115,111,632.68	115,111,632.68
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,179,073.38	4,147,392.37	431,072,769.49	599,399,235.24
10	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	164,179,073.38	4,147,392.37	431,072,769.49	599,399,235.24
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			73,422.15	73,422.15
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-73,422.15		-73,422.15
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			167,168,204.97	167,168,204.97
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,179,073.38	4,073,970.22	598,314,396.61	766,567,440.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,081,531,500.00	2,068,589,343.76	12,942,156.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,081,531,500.00	2,068,589,343.76	12,942,156.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,035,676,700.00	2,024,650,439.01	11,026,260.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,651,496,200.00	1,651,188,025.82	308,174.18
210101	Үндсэн цалин	687,962,800.00	727,001,431.82	-39,038,631.82
210102	Нэмэгдэл	804,952,500.00	839,621,740.00	-34,669,240.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	99,820,000.00	43,528,864.00	56,291,136.00
210104	Урамшуулал	58,760,900.00	41,035,990.00	17,724,910.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,296,100.00	205,271,570.38	24,529.62
210201	Тэтгэврийн даатгал	139,601,300.00	142,637,947.83	-3,036,647.83
210202	Тэтгэмжийн даатгал	16,423,700.00	16,611,839.00	-188,139.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,211,900.00	8,232,659.83	-20,759.83
210204	Ажилгүйдлийн даатгал	8,211,900.00	7,557,825.04	654,074.96
210205	Эрүүл мэндийн даатгал	32,847,300.00	30,231,298.68	2,616,001.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,439,500.00	46,429,985.81	9,514.19
210301	Гэрэл, цахилгаан	6,295,200.00	4,266,493.21	2,028,706.79

210302	Түлш, халаалт	36,910,000.00	39,871,337.60	-2,961,337.60
210303	Цэвэр, бохир ус	3,234,300.00	2,292,155.00	942,145.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,083,400.00	38,192,128.00	7,891,272.00
210401	Бичиг хэрэг	3,610,000.00	2,910,000.00	700,000.00
210402	Тээвэр, шатахуун	27,940,200.00	22,741,030.00	5,199,170.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,808,700.00	1,803,538.00	1,005,162.00
210404	Ном, хэвлэл	1,600,000.00		1,600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,124,500.00	10,737,560.00	-613,060.00
2105	Нормативт зардал	9,720,000.00	9,720,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,720,000.00	9,720,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,289,100.00	49,180,650.00	108,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,071,100.00	4,071,100.00	
210602	Тавилга	25,000,000.00	25,000,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,056,000.00	2,056,000.00	
210604	Урсгал засвар	18,162,000.00	18,053,550.00	108,450.00
2107	Томилолт, зочны зардал	8,440,100.00	7,370,000.00	1,070,100.00
210702	Дотоод албан томилот	8,440,100.00	7,370,000.00	1,070,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,412,300.00	10,266,579.00	1,145,721.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,383,200.00	4,383,200.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	1,610,000.00	1,610,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	402,500.00	242,379.00	160,121.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	77,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,485,600.00	3,522,000.00	963,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,500,000.00	7,031,500.00	468,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,500,000.00	7,031,500.00	468,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,854,800.00	43,938,904.75	1,915,895.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,854,800.00	43,938,904.75	1,915,895.25
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,854,800.00	40,938,904.75	1,915,895.25
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	3,000,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох			
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг			
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			
	Дотоод эх үүсвэрээр			
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,081,531,500.00	2,068,589,343.76	12,942,156.24
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,081,531,500.00	2,068,039,343.76	13,492,156.24
132001	Орон нутгийн төсвөөс	2,081,531,500.00	2,068,039,343.76	13,492,156.24
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС			

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		550,000.00	-550,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		550,000.00	-550,000.00
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	
3	Төсвийн байгууллага	1	1	
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	50	47	3
6	Удирдах ажилтан	1	1	
7	Гүйцэтгэх ажилтан	42	39	3
8	Үйлчлэх ажилтан	7	7	
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ			

2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦӨВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		12,300,000.00	-12,300,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		12,300,000.00	-12,300,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		12,300,000.00	-12,300,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил			
210101	Үндсэн цалин			
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл			
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал			
2104	Хангамж, бараа материалын зардал		4,330,000.00	-4,330,000.00
210402	Тээвэр, шатахуун		4,330,000.00	-4,330,000.00
2105	Нормативт зардал			
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		300,000.00	-300,000.00
210604	Урсгал засвар		300,000.00	-300,000.00
2107	Томилолт, зочны зардал		3,590,000.00	-3,590,000.00
210702	Дотоод албан томилолт		3,590,000.00	-3,590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,080,000.00	-4,080,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,080,000.00	-4,080,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал			
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ			
2132	Бусад урсгал шилжүүлэг			
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			
	Дотоод эх үүсвэрээр			
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		12,300,000.00	-12,300,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		12,300,000.00	-12,300,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,000,000.00	-12,000,000.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		300,000.00	-300,000.00
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа, зорилго, зорилт

Нийгэм эдийн засгийн хөгжлийг экосистемийн даацад тохируулан байгаль орчны тэнцлийг хангах, байгалийн баялгийг тогтвортой ашиглах, жам ёсоор нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх замаар ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлэх замаар хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино. Бүх нийтийн оролцоотой, хэмнэлттэй, бүтээмжтэй, хүртээмжтэй байгаль хамгааллыг төлөвшүүлэхэд эрхэм зорилго нь оршиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын болон татварын багц хууль, Байгаль орчны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагын үйл ажиллагаандаа өдөр тутам хэрэгжүүлэн мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар сйлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн байна.

Байгаль орчны газар нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Байгал орчны газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 177,671.2 мянган төгрөгөөр буюу 29.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт		/мянган төгрөгөөр/		
Б	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө				
Авлага		15.0	15.0	
Урьдчилгаа				
Бараа материал	326,053.0	323,325.0	-2,728.0	
Үндсэн хөрөнгө	273,346.2	453,730.4	180,384.2	
Нийт хөрөнгө	599,399.2	777,070.4	177,671.2	
Өр төлбөр		10,503.0	10,503.0	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	599,399.2	766,567.4	167,168.2	
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө /өмчийн дүн	599,399.2	777,070.4	177,671.2	

Мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардлын эхний болон эцсийн үлдэгдэл байхгүй, авлагын эхний үлдэгдэл байхгүй эцсийн үлдэгдэл 15.0 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 323,325.0 мянган төгрөг болж 2,728.0 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын дансанд байсан аялал жуулчлалын хөтөч ном, аялал жуулчлалын танилцуулга зарлагдаж соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийн газарт шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 453,730.4 мянган төгрөг болж 180,384.2 мянган төгрөгөөр өссөн нь Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас ирүүлсэн Ланд-76 авто машин хөрөнгөд орлого авсан, мөн мэргэжлийн хяналтын газрын хөрөнгийг үндсэн хөрөнгөд орлого авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл байхгүй эцсийн үлдэгдэл 10,503.0 мянган төгрөг байгаа нь зарцуулалтын эрх нээж өгөөгүйгээс шалтгаалан үүссэн түлш халаалт, тээвэр шатахуун, шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зардлын байгууллагад төлөх өглөг болон хувь хүмүүст төлөх албан томилолтын өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 766,567.4 мянган төгрөг болж 167,168.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 106,704.1 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна. Орлого өсөхөд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлого голлон нөлөөлсөн байна. Нийт зардал өмнөх оноос 37,232.6 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна. Зардал өсөхөд цалингийн зардлын өсөлт голлон нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,369,721.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 288,189.9 мянган төгрөгөөр бууруулж 2,081,531.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7141 хөтөлбөрийн 80101 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,081,531.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 550.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,081,531.5 мянга, өөрийн орлого 550.0 мянга, нийт 2,082,081.5 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,068,589.3 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байна.

Зарцуулаагүй үлдэгдэл 13,492.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	71411/80101	1,989,237.2	1,978,220.4	11,016.8	99.44	
2	71411/80111	46,439.5	46,430.0	9.5	99.98	
3	71411/80802	45,854.8	43,938.9	1,915.9	95.82	
4	Өөрийн орлого	-	550.0	550.0		
	Нийт			13,492.2	99.38	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

					/мянган төгрөг/	
№	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар	
1	Программ хангамжийн бүртгэл		2,995.0		Санхүүгийн CTSYSTEM 6.5, Acolous	
2	Унаа, хоолны зардал	99,820.0	43,528.9	56,291.1	Ажилтнуудад хоолны хөнгөлөлтийг 1 хоногт 15.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.	
3	Сургалт, семинар	7,500.0	7,031.5	468.5	Байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нарыг төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд сургалтад хамруулсан.	
4	Гадаад томилолт, арга хэмжээ		0.0		Зардал гараагүй.	
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал		0.0		Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.	
6	Орон тооны цомхотгол		-		2025 онд анх батлагдсан орон тоо 50, тодотгол Сангийн яамнаас 44 болсон боловч, орон нутгийн зүгээс бүтэц орон тоонд өөрчлөлт оруулаагүй, төсвийн санхүүжилт 47 орон тоогоор батлагдаж, гүйцэтгэлээр 47 орон тоотой байна.	
7	Хэвлэл, мэдээлэл	1,200.0	1,200.0		Байгууллагын мэдээ, мэдээлэл ард иргэдэд хүргэх.	

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 12,000.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 300.0 мянга, нийт 12,300.0 мянган төгрөгийн орлого бүртгэсэн байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас тээвэр шатахууны зардалд 4,330.0 мянга, урсгал засвар 300.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардалд 4,080.0 мянга, дотоод албан томилолтын зардалд 3,590.0 мянга, нийт 13,300.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Байгаль орчны газар нь 2025 онд тендерээр худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,148,145.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 21,481.4 мянган төгрөгөөс 80

хувиар тооцож 17,185.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,185,378.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 21,853.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 17,483.0 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Байгаль орчны газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгаль орчны газар нь Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 168, хугацаа хоцроож оруулсан 1, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам”-ын 1.2 дахь заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.НАМЖИЛ/

2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр